



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 8/258

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тавдугаар хуралдааны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.11, 5.12 дахь заалтын дагуу тарвасны Буянт 1 сортыг сайжруулж, үр үржүүлж, үрийн нөөц бүрдүүлэх 10,000,000 төгрөг, ургамал хамгааллын бодисыг худалдан нийлүүлэх 20,000,000 төгрөгийн санхүүжилтийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Бямбажав)-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 05 дугаар сарын 25-ны дотор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 22-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтад хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 05 сарын 30-ны дотор тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Бямбажав)-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д хариуцуулсугай.

8400 01.1325  
2022.05.04

- 4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх), өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Ш.Нохойжав), холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт үүрэг болгосугай.
- 5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.



Б.ДУГЭРЖАВ